



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2021 оны 09 сарын 29 өдөр

Дугаар A/464

Арвайхээр

Газар эзэмшүүлэх төсөл сонгон шалгаруулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29.2 дахь заалт, Газрын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.2 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 10 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан “Газар эзэмшүүлэх, ашиглуулах төсөл сонгон шалгаруулах журам”, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны “Арвайхээр сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө шинэчлэн батлах тухай” 12/05 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Арвайхээр сумын төвийн инженерийн шугам сүлжээ бүхий газарт төсөл сонгон шалгаруулалтаар эзэмшүүлэх 1 нэгж талбарын газрын хэмжээ, байршил, зориулалтыг хавсралтаар баталсугай.

2. Газар эзэмшүүлэх, ашиглуулах төсөл сонгон шалгаруулалтыг цахим хэлбэрээр явуулах бөгөөд төсөл сонгон шалгаруулалтыг 2021 оны 11 дүгээр сарын 29-ний өдөр зохион байгуулсугай.

3. Төсөл сонгон шалгаруулалт явуулах тухай зар мэдээг 2021 оны 09 дүгээр сарын 29-ний өдрөөс эхлэн олон нийтэд зарлаж, холбогдох журмын дагуу оролцогчдын материалыг хүлээж авахыг аймгийн Засаг даргын дэргэдэх Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Т.Ариунболд)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

А.ИШДОРЖ



011100987

D:My Doc. Zahiramj. Zasag darga

Аймгийн Засаг даргын 2021 оны 09.
дугаар сарын 29.-ны өдрийн 11/14 дугаар
захирамжийн хавсралт

АРВАЙХЭЭР СУМЫН ИНЖЕНЕРИЙН ШУГАМ СҮЛЖЭЭ
БҮХИЙ ГАЗАРТ ТӨСӨЛ СОНГОН ШАЛГАРУУЛАЛТААР ЭЗЭМШҮҮЛЭХ
ГАЗРЫН БАЙРШИЛ, ЗОРИУЛАЛТ, ХЭМЖЭЭ

№	Төлөвлөж буй газрын байршил	Төлөвлөл тийн нэгж талбарын дугаар	Зориулалт	Хэмжээ /га/
1	Арвайхээрийн 5 дугаар баг, Үйлдвэрлэлийн бүс	2264132	Үйлдвэрлэлийн барилга байгууламж, бусад газар	2
ДҮН				2

-оо-

